

Монголын Геологийн алба

Нэг. Өмнөх үг

Геологи, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг судалгаа, шинжилгээний байгууллагуудыг нэгтгэх замаар “Эрдэс баялгийн үндэсний төв”-ийг байгуулах санал, үндэслэлийг боловсруулах тухай ЭБЭХС, ШУА-ийн ерөнхийлөгчийн 2010 оны 18/13 дугаар хамтарсан тушаал, Монгол улсын Геологийн албаны бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулах Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 042 дугаар тушаалаар ажлын хэсгүүд байгуулан улмаар боловсруулсан саналыг 2011 оны 8, 9 дүгээр сард ЭБЭХС-ын дэргэдэх Эрдэс баялгийн бодлогын зөвлөлөөр хэлэлцүүлж, Монголын геологийн албыг Яамны харьяа агентлагийн түвшинд байгуулах нь зүйтэй гэсэн нэгдсэн санал, дүгнэлтэнд хүрсэн байна. Уг төсөлд яамдын санал авч 2012 оны 03 дугаар сард Засгийн газарт хүргүүлсэн.

- **УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор** батлагдсан Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Геологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд **Монголын Үндэсний Геологийн албыг** шинээр байгуулах”-аар тусгагдсан.
- Уул уурхайн сайдын 2012 оны 12 дугаар сарын 11-ний Өдрийн 78 дугаар тушаалаар Үндэсний Геологийн алба байгуулах талаар туршлага судлах, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулсан.

Хоёр. Өнөөдрийн байдал

- АМГ-ын Геологийн алба нь нийт 40 мэргэжилтэнтэй, үүнээс 25 нь Төрийн захиргааны албан хаагч, 15 нь төрийн үйлчилгээний алба хаагчид.
 - Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа зураглал болон сэдэвчилсэн судалгаа хариуцсан Региональ геологийн тасаг, хувийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологи-хайгуулын ажил хариуцсан Эрдэс баялгийн судалгааны тасаг болон Монгол улсын хэмжээнд хийгдсэн геологи, эрдэс баялгийн мэдээлэл хадгалж хамгаалж, үйлчилгээ үзүүлж байгаа Геологийн мэдээллийн төв гэсэн 3 нэгжтэй.

- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 7,4 тэрбум төгрөг бүхий 62 төслийн геологийн даалгавар боловсруулах, төсөл, төсвийг хянах, төсвийн нэгтгэлийг хийх, хээрийн шуурхай хяналт хийх болон хээрийн материалыг хүлээн ажлыг гүйцэтгэж байна.
- Хайгуулын 1648 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс /2014-02-20-ны байдлаар/ 1134 /69 %/ нь тайлангаа, 140 /8.5%/ нь төлөвлөгөөгөө ирүүлсэн байна. Мөн 2014 онд ЭБМЗ--өөр нөөцийн тооцоо бүхий 48 тайланг хянасан байна.

Гурав. Цаашид авах арга хэмжээний талаар

- Монголын Үндэсний Геологийн албыг Геологийн төв лаборатори”, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ, АМГ-ын геологийн алба, төслүүдийг нэгтгэх замаар үүсгэн байгуулах нь зүйтэй гэсэн саналтай ба холбогдох хуулиудад заасны дагуу
 - Монгол улсын нутаг дэвсгэрийн геологи, геохими, гидрогеологийн зураглал, геофизик, ашигт малтмалын зүй тогтол, хэлбэршилтийн судалгаа хийж, эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ өгч эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх,
 - геологийн суурь судалгаа, эрэл хайгуулыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж, шинээр орд илрэл нээн улсын эрдэс баялгийн санг өсгөн нэмэгдүүлэх,
 - геологи, ашигт малтмалын талаарх бүхий л мэдээллийг төр өөрийн мэдэлдээ байлгах,
 - төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг нэгтгэсэн нэгдмэл тогтолцоог бий болгох ач холбогдолтой юм.

4. *“Монголын Үндэсний Геологийн Алба”-ны бүтэц, зохион байгуулалт /төсөөлөл/*

- Захиргаа, санхүү, аж ахуйн газар
- Стратеги төлөвлөлт, эдийн засгийн газар /одоогийн Геологийн алба/
- Геологи, эрдэс баялгийн судалгааны газар /одоогийн Геологийн судалгааны төв/
- Геологийн мэдээллийн төв/одоогийн Геологийн мэдээллийн төв дээр суурилсан/
- Олон улсад итгэмжлэгдсэн лаборатори/одоогийнГТЛ /
- Үйлдвэр, техникийн газар

бүхий геологийн нэгдсэн бүтэцтэй байх бөгөөд геологийн нөөцийг бүртгэж авдаг өөрийн бие даасан Шинжлэх ухаан техникийн зөвлөлтэй байна.

Гадаад бүтэцдээ Геологи, Эрдэс баялгийн хүрээлэнтэй нягт хамтран ажиллах бөгөөд нийт орон тоо 250 орчим хүнтэй байна.

Тав. Монголын Үндэсний Геологийн алба дараах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:

- - Дэлхийн геологийн шинжлэх ухааны дэвшилтэт онол, судалгааны орчин үеийн арга аргачлалуудыг Монголын геологийн судалгаанд нутагшуулах,
- - Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд давхарга зүй, магматизм, тектоник, ашигт малтмалын чиглэлээр регионал геологи, геохими, геофизикийн цогцолбор судалгааг хэрэгжүүлж Монгол орны геологийн тогтоц, түүхийг судлан тогтоох, ашигт малтмалын шинэ ордуудыг нээн илрүүлж үнэлгээ өгөх,
- - Улсын төсвийн хөрөнгөөр геологийн зураглал, төрөл бүрийн сэдэвчилсэн судалгаа, ашигт малтмалын ордын эрэл, хайгуулын ажлыг гүйцэтгэх,
- - Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлын жилийн болон эцсийн үр дүнгийн тайланг хүлээн авч хэлэлцэх, геологийн нөөцийг бүртгэж сан бүрдүүлэх,

- - Монгол орны эдийн засгийн бүсүүдийн болон бүс нутгийн хэмжээнд ашигт малтмалын, геоэкологи, геологи-эдийн засгийн үнэлгээ өгөх,
- - Геологийн төрөл бүрийн судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулж, геомэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах,
- - Хурдас чулуулаг, ашигт малтмалын бүх төрлийн шинжилгээг олон улсад итгэмжлэгдсэн лабораторийн түвшинд хийж гүйцэтгэх,
- - Усан хангамжийн судалгаа, газар доорхи усны эх үүсвэрийн эрэл, хайгуул, гидрогеологи, геоэкологийн судалгаа, байгалийн болзошгүй аюул гарч болох эрсдлийг судлан, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх,

- - Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын жилийн төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх,
- - Бүх төрлийн геологийн судалгааны ажлын арга аргачлал, заавар, журам, ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавих шаардлагыг боловсруулан батлуулж мөрдүүлэх,
- - Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд бий болсон том болон томоохон ордуудын хэмжээнд хяналтын геологийн судалгаа хийх болон тухайн ордуудын хэмжээнд болон чулуун сангийн дээжээр сан бүрдүүлэх,

Анхаарал тавьсанд баярлалаа.